2.Захиалагч нь ажил гүйцэтгэхэд үүссэн хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзсэний үндсэн дээр явцын тайлан хүлээлгэн өгөх хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл сунгав.

3.Энэхүү нэмэлт гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн **НХААГ/20250103049** дугаартай үндсэн гэрээгээр зохицуулна.

4.Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно. (цаашид "Гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Хавсралт №1 гэрээний тусгай нөхцөл

Хавсралт №2 тайлан гаргах хуваарь

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Г.Баярсайхан

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
"ГОБИ ТРАВЕЛ" ХХК-ийн захирал
................................/С.БАТЧИМЭГ/

"Шаргаморьт" дагуул хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгө (1,065,800,000)-ийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 24/50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 180 дугаарт батлагдсан "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" багц төсөл, арга хэмжээний багцаас санхүүжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх захирамж гаргуулах тухай" 2025 оны 01/470 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.

Мөн тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврын төслийг газрын 1 алба, 10 хэлтсээс санал авч боловсруулан байршлын схемийн хамт бэлтгэсэн. Эрх шилжих тухай захирамж баталгаажсаны дараа ажлын даалгаврыг батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 28 өдөр Дугаар 25/50 Улаанбаатар хот

Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

**Нэг.** Нийслэлийн 2025 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

*(мянган төгрөгөөр)*

| | | |
|---|---|---|
| **1.** | **Нийслэлийн төсвийн нийт орлого** | **1,688,611,923.7** |
| **1.1.** | **Татварын орлого** | **1,080,723,164.0** |
| 1.1.1. | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар | 940,900,000.0 |
| 1.1.2. | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (60,000,000.0) |
| 1.1.3. | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 120,273,700.0 |
| 1.1.4. | Газрын төлбөр | 40,000,000.0 |
| | Үүнээс:Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт | 40,000,000.0 |
| 1.1.5. | Ус ашигласны төлбөр | 4,718,100.0 |
| 1.1.6. | Ойгоос мод ашигласны төлбөр | 24,864.0 |
| 1.1.7. | Нийслэл хотын албан татвар | 34,806,500.0 |
| **1.2.** | **Татварын бус орлого** | **583,770,539.4** |
| 1.2.1. | Хувьцааны ногдол ашиг | 1,533,800.0 |
| 1.2.2. | Төрийн өмч түрээслүүлсний төлбөр | 3,068,900.0 |
| 1.2.3. | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 49,172,656.7 |
| 1.2.4. | Авто зам ашигласны төлбөр | 100,598,300.0 |

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР**
Наадамчдын зам 1201, Арцатын ам, 23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2025.05.05 № 01/470
танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

Хүсэлт хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын "Хот байгуулах тухай" 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт "Шаргаморьт" дагуул хот байгуулахаар баталсан бөгөөд тус дагуул хотын хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 24/50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 180 дугаарт батлагдсан "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" багц төсөл, арга хэмжээний задаргаанд тусгаж, санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Дээрх багц төсөл, арга хэмжээний задаргаа нь орон нутгийн зэрэглэлтэй хотуудын хил заагийн асуудлаас шалтгаалан удаашírснаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэлтэд тооцогдох нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Иймд "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" багц төсөл, арга хэмжээнээс санхүүжихээр төлөвлөсөн, ажлын даалгавар нь боловсруулагдсан "Шаргаморьт" дагуул хотын хот байгуулалтын




*1.1.1.1. – 4. Орон нутгийн зэрэглэлтэй 14 хот (Хан-Уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах.*

Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, дагуул 3 хотуудыг байгуулсан.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 05 өдөр | Дугаар 72 | Төрийн ордон, Улаанбаатар хот

**ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 2 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан улс болон орон нутгийн зэрэглэлтэй дараах хотуудыг байгуулсугай:

| Д/д | Хотын нэр | Харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот | Газар зүйн байршил |
|---|---|---|---|
| Нэг.Улсын зэрэглэлтэй хот | | | |
| 1 | Дархан хот | Дархан-Уул аймаг | Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор сумын нутаг дэвсгэр |
| 2 | Эрдэнэт хот | Орхон аймаг | Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг дэвсгэр |
| 3 | Зуунмод хот | Төв аймаг | Төв аймаг Зуунмод сумын нутаг дэвсгэр |
| 4 | Хархорум | Өвөрхангай аймаг | Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Өгийнуур, Хашаат сумын нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээнд авсан газар |
| 5 | Багануур хот | Нийслэл Улаанбаатар хот | Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэр |
| 6 | Налайх хот | | Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэр |
| Хоёр.Орон нутгийн зэрэглэлтэй хот | | | |
| 1 | Хан-Уул хот | | Нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр |
| 2 | Яармаг хот | | Нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Сүхбаатар хот | | Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр |
| 12 | Дарь-Эх хот | | Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр |
| 13 | Баянзүрх хот | | Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр |
| 14 | Амгалан хот | | Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр |
| 15 | Цэцэрлэг хот | Архангай аймаг | Архангай аймгийн Эрдэнбулган сумын нутаг дэвсгэр |
| 16 | Өлгий хот | Баян-Өлгий аймаг | Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дэвсгэр |
| 17 | Баянхонгор хот | Баянхонгор аймаг | Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэр |
| 18 | Булган хот | Булган аймаг | Булган аймгийн Булган сумын нутаг дэвсгэр |
| 19 | Алтай хот | Говь-Алтай аймаг | Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэр |
| 20 | Чойр хот | Говьсүмбэр аймаг | Говьсүмбэр аймгийн Чойр сумын нутаг дэвсгэр |
| 21 | Сайншанд хот | Дорноговь аймаг | Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэр |
| 22 | Замын-Үүд хот | Дорноговь аймаг | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр |
| 23 | Чойбалсан хот | Дорнод аймаг | Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэр |
| 24 | Мандалговь хот | Дундговь аймаг | Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг дэвсгэр |
| 25 | Улиастай хот | Завхан аймаг | Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэр |
| 26 | Тосонцэнгэл хот | Завхан аймаг | Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутаг дэвсгэр |
| 27 | Арвайхээр хот | Өвөрхангай аймаг | Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын нутаг дэвсгэр |
| 28 | Хархорин хот | Өвөрхангай аймгийн Хархорин сум | Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэр" |
| 29 | Даланзадгад хот | Өмнөговь аймаг | Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэр |
| 30 | Ханбогд хот | Өмнөговь аймаг | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр |
| 31 | Цогтцэций хот | Өмнөговь аймаг | Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэр |
| 32 | Баруун-Урт хот | Сүхбаатар аймаг | Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутаг дэвсгэр |
| 33 | Сүхбаатар хот | Сэлэнгэ аймаг | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын нутаг дэвсгэр |
| 34 | Хөтөл хот | Сэлэнгэ аймаг | Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэр |
| 35 | Мандал хот | Сэлэнгэ аймаг | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэр |

*1.1.2.11. – 21. Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт үе шаттай шилжүүлэх*

Гэр хорооллын айл өрхүүдийг үе шаттайгаар хийн болон цахилгаан халаагуурт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн.  Тус ажлын хүрээнд 100000 гэр хорооллын айл өрхүүдийг 2025-2028 онуудад үе шаттайгаар хийн түлш болон цахилгаан руу шилжүүлнэ.  Мөн байршлын саналыг Улаанбаатар хотын 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж зураглал бэлдсэн. Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-д 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/360 дугаар бүхий албан бичгээр 4 байршилд  санал хүргүүлсэн. Тус байшрлуудаас  БЗД-ийн 21 хороо, СХД-ийн 8 хороонд Шингэрүүлсэн байгалийн хийн дулааны дэд станц барьж байгуулах боломжтой,  үлдсэн 2 байршил буюу БЗД Алтан -Өлгий

орчимын газрууд  нүүлгэн шилжүүлэх ажил урт хугацаа өндөр өртөгтэй ажил байсан тул дахин Цагаан давааны урд талын байршилд саналаа 2025 оны 01/1203 тоот албан бичгээр хүргүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2025.04.10 № 01/360
танай ______ -ны № ______ -т

ТАРХМАЛ ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮТЭЦ ХХК-Д

Санал хүргүүлэх тухай

Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийг сайжруулсан шахмал түлшнээс хийн түлшинд шилжүүлэх ажлын хүрээнд шингэрүүлсэн байгалийн хий хадгалах, дахин хийн төлөвт хувиргах станцыг барьж байгуулах ажилд танай ирүүлсэн саналыг Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл болон Хот байгуулалтын мэдээллийн сантай уялдуулж үзлээ.

Баянзүрх дүүргийн 21, 31 дүгээр хорооны нутаг дэвсгэрт төлөвлөсөн 2 байршилд төлөвлөлтийн авто зам, болон үерийн эрсдэлтэй бүсэд байрлаж байгаа тул өөрчлөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд Танай ирүүлсэн 3 байршил тус бүрийн саналыг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан судлан хүргүүллээ тус саналыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

Хот байгуулалт хотын стандартын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ганболд БАЯРСАЙХАН
2025.04.10 10:20

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uds.ub.gov.mn

2025.10.13 № 01/1203
танай ______ -ны № ______ -т

ТАРХМАЛ ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮТЭЦ ХХК-Д

Хариу хүргүүлэх тухай

Тус газарт "Тархмал эрчим хүчний дэд бүтэц" ХХК-аас Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах газрыг "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-нд тусгуулах тухай хүсэлтийг хүлээн авч судлан үзлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төслийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчлэлд нийцүүлэн боловсруулах үүрэг өгөгдсөний дагуу Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1189 дүгээр захирамжийн хүрээнд "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичгийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" төслийг хэлэлцэх асуудал  дэмжигдсэн.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шатанд тухайн асуудлыг тусгах боломжтой.

Хот байгуулалт хотын стандартын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ганболд БАЯРСАЙХАН
2025.10.13 14:20

*1.1.3.4. – 31. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинээр барих үйл ажиллагааны журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01//574 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.05.21 № 05-02/3315
танай ______ -ны № ______ -т

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАЯРСАЙХАН ТАНАА

Санал ирүүлэх тухай

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Нийслэлийн Засаг даргад хандаж Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Сайдын тушаалын төсөл боловсруулж ирүүлсэн байна.

Журмын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа тус газарт 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн дотор тус газарт ирүүлнэ үү.

Хавсралт 15 хуудастай.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА М.ҮНЭНБАТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uds.ub.gov.mn

2025.05.26 № 01/574
танай 2025.05.21 -ны № 05-02/3315 -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйлд ажиллагааны журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай сайдын тушаалд төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан график төлөвлөгөөг баримталж ажиллах үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчлэн батлуулж болно. Батлагдсан график төлөвлөгөөг шинэчлэн батлуулах хүсэлт гурваас илүүгүй байх ба шинэчлэн батлуулсан төлөвлөгөөний дагуу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаандаа барилгыг улсын комисст хүлээлгэн өгч чадаагүй тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг цуцлах тухай заалт тусгах саналтай байна.

Хот байгуулалт хотын стандартын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ганболд БАЯРСАЙХАН
2025.05.26 09:32

*1.1.3.4. – 35. 2002 оноос өмнө баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийж, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах.*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/28 дугаар захирамжаар газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажилд 200.000,000 төгрөгийн эрх шилжиж ирсэн. Тус захирамжийн хүрээнд Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, орон сууц болон олон нийтийн 23 барилгад газар хөдлөлтөд тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулахаар батлагдсан.

Тус ажлын тендерийг худалдан авах ажиллагааны цахим системээр 2025.04.21-ний өдөр олон нийтэд нээлттэй зарлаж, нээлтийг 2025.05.13-ны өдөр хийж, ажил гүйцэтгэх гэрээг “Онч тэнхлэг” ХХК-тай 2025.05.26-ны өдөр байгуулан Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Гүйцэтгэгч гэрээний дагуу эцсийн тайлангийн гүйцэтгэлийг 2025.10.31-ний өдөр 23 барилгын дүгнэлтийг ирүүлсэн бөгөөд тус тайлан хянагдаж байна.



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/28 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 55 дугаар зүйлийн 55.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.18, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1-т заасны дагуу барилга байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулах ажилд 200,000,000 (хоёр зуун сая), төлөвлөгөөний 1.2-т заасны дагуу хүчтэй газар хөдлөлт болсон үед газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийг тодорхойлох зорилгоор хөрсний хурдатгал бичигч станц суурилуулах ажилд 90,000,000 (ерэн сая) төгрөг, нийт 290,000,000 (хоёр зуун ерэн сая) төгрөгийн зарцуулах эрхийг Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т шилжүүлсүгэй.

2.Шаардагдах зардлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн төсвөөс гаргахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулан, тайлан мэдээг 2025 оны 10 дугаар сард багтаан Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлд тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Батбямба)-д үүрэг болгосугай.

ДАРГА А.БАЯР



ОНЧ ТЭНХЛЭГ
БАРИЛГА УГСРАЛТ, ЗУРАГ ТӨСӨЛ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 11-р хороо, Pro One оффис 13-н давхар #1307 тоот
Утас: 99007155, 99194350
И-мэйл: onchtenkhleg@gmail.com

2025 оны 10 сарын 31 өдөр Дугаар 181/25 Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР-т

*Хүсэлт гаргах тухай:*

Манай компани нь Хот байгуулалт, хотын стандартын газраас зарласан Барилга байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах НХБХГ/20250101002/01/01 урилгын дугаартай тендерт оролцож, гүйцэтгэгчээр шалгарсан бөгөөд 2025 оны 05-р сарын 22-ны өдрийн ХБХСГ/20250101002/01/01 дугаартай гэрээ байгуулсан билээ.

Гэрээт ажлын дагуу инженер геологийн судалгааны ажил болон түүнийг магадлалаар батлуулах, тоосго болон өргийн зуурмагаас дээж авч лабораторид шинжлүүлэх, барилга дээр биет үзлэг, хэмжилт судалгаа хийх, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд зориулсан хэмжилтийн зураг төсөл боловсруулах, үндсэн бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх тооцоог хийж үр дүнг нэгтгэн ажлын даалгавар дах барилга байгууламжуудын нэгдсэн дүгнэлтийн тайлангуудыг боловсруулаад байна.

Иймд бидний хүргүүлж буй гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, ажил гүйцэтгэх гэрээний 5-р зүйлийн дагуу санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу олгож өгнө үү.

Гүйцэтгэсэн ажлын тайлан болон холбогдох бичиг баримтыг хавсаргав.

ХҮНДЭТГЭСЭН: ЗАХИРАЛ Б.БАДАМЦЭЦЭГ

*1.1.3.7. – 41. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл хотын стандартыг батлуулах*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор “UCS1101C:2025 Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандарт батлагдсан. Тус стандарт нь 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Тухайн стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд “Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв”-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр ногоон эрчим хүчний хэмнэлттэй амины сууцтай болох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдтэй “Эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн хийг бууруулсан ногоон амины орон сууцны чадавхжуулах сургалт”-ыг зохион байгуулж сертификат олгосон.



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр Дугаар 25/07 Улаанбаатар хот

Нийгмийн дэд бүтцэд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн $10^1$ дүгээр зүйлийн $10^1$.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн "Нийгмийн дэд бүтэц" бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1.UCS1106B:2025 "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага" хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2.UCS1107B:2025 "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага" хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3.UCS1108B:2025 "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага" хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4.UCS1109B:2025 "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага" хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5.UCS1101C:2025 "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2.Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА А.БАЯР










## *4.3.1.3. – 1183. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах*

1. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 209 дүгээр тогтоолын дагуу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын эзэмшлийн 341га талбайд "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын туршилтын бүс"-ийн зурвасын мэдээллийг eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим системд бүртгэж оруулсан.

2. Хот байгуулалтын тухай хуулийн 49.1.4. хот, суурин газрын хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хот байгуулалтын бүсчлэлд тавигдах шаардлагад нийцүүлэн газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, барилга байгууламж барих, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн зураг төслийн дагуу гүйцэтгэх гэж заасны дагуу “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын туршилтын бүс”-ийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлуулах шаардлагатай талаар "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-т 2025 оны 02/80 дугаар албан бичгээр хүргүүлэв.



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ
РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТҮГ

16066 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, Амарсанаагийн гудамж
Утас: 75112020, Факс: (976)70189980
Цахим шуудан: info@rtbn.gov.mn
Цахим хуудас: rtbn.gov.mn

2025.04.28 № 01/135

танай ____ -ны № ____ -т

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАРТ

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 209 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллага болон сонирхогчийн үйл ажиллагаанд дрон ашиглах зориулалтаар туршилтын бүсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нийслэлийн Баянзүрх, Налайх, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт байгуулах арга хэмжээ авах”-ыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Зам, тээврийн сайд, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга болон холбогдох Засаг дарга нарт даалгасан билээ.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-н эзэмшил болох Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхорт байрлах 341 га талбайд нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын туршилтын бүс байгуулах ажил эхлүүлэх гэж байгаа тул хотын мэдээллийн санд бүртгэж холбогдох хууль дүрэм журмын дагуу зөвлөмж өгч хамтран ажиллана уу.

Радиотелевизийн үндэсний сүлжээ УТҮГ
Удирдлага
Захирал
Жаргалсайхан Энхбат
2025-04-28 14:46:18



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

Наадамчдын зам 1201, Арцатын ам, 23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uds.ub.gov.mn

2025.05.23 № 02/80

танай 2025.04.28 -ны № 01/135 -т

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТҮГ-Т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 209 дүгээр тогтоолын дагуу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын эзэмшлийн 341га талбайд “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын туршилтын бүс”-ийн зурвасын мэдээллийг eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим системд бүртгэж оруулсан.

Хот байгуулалтын тухай хуулийн 49.1.4. хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хот байгуулалтын бүсчлэлд тавигдах шаардлагад нийцүүлэн газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, барилга байгууламж барих, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн зураг төслийн дагуу гүйцэтгэх гэж заасны дагуу “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ын туршилтын бүс”-ийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлуулах шаардлагатай.

Хот байгуулалт хотын стандартын газар
Захиргаа удирдлагын хэлтэс
Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Даш ДАШЦЭЦЭГ
2025.05.26 09:19

*(Хот байгуулалт, хотын стандартын газар)*